



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/65

Дэлгэрхаан сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, "Газрын тухай" хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээгээ шилжүүлэх хүсэлт гаргасан иргэн /ЧЖ79082873/ регистрийн дугаартай Л.Энхбатын үр тарианы усалгаатай тариалангийн зориулалттай 3200000 м2 талбайтай 2320011517 нэгж талбарын дугаартай газрыг иргэн /У389120653/-ын дугаартай С.Батсайханд 40 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэнтэй гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ч.Батзориг)-т үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж, гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг (С.Батсайхан)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/63 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



БЭНХ-АМГАЛАН

2329010124

